

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

АЙМГИЙН ЦАГДААГИЙН ГАЗРЫН ТЭЭВРИЙН
ХЭРЭГСЭЛ ТҮР СААТУУЛАХ ХАШАА /БАЙР/-НЫ
ОРЛОГЫГ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ДАГУУ БҮРЭН
ТӨВЛӨРҮҮЛСЭН ЭСЭХ, ТҮҮНИЙ ЗАРЦУУЛАЛТАД
ХИЙСЭН НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: БНА-2019/35/-НА

Баянхонгор 2019 он

Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат

Утас: 99007576 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Цэцэгмаа

Утас: 88089024 Цахим хаяг: tsetsegmaadam@audit.gov.mn

Ахлах аудитор: А.Цээням

Утас: 99442140 Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn

Аудитор: Г.Ганчимэг

Утас: 88268424 Цахим хаяг: ganaa_7133@yahoo.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт
мэдээллийг дараах хаягаар авна уу.

Цахим хуудас: www.audit.mn



АГУУЛГА

Аудитын зорилт, арга зүй, стандартын талаарх мэдэгдэл	2
Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх	2
Аудитын зорилт	2
Аудитын хамарсан хүрээ	2
Аудитын арга зүй	2
Аудитын дүн	4
Бүлэг1 Тээврийн хэрэгсэл түр саатуулах хашаа/байр/-ны зарим үйл ажиллагаа нь журамд нийцэхгүй байна.	4
Бүлэг2: Тээврийн хэрэгслийг түр саатуулах хашаа/байр/-ны орлогыг бүрэн төвлөрүүлээгүй байна.	7
АУДИТЫН ДҮГНЭЛТ	10
АУДИТЫН ЗӨВЛӨМЖ	10

Тайланг хянасан:

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газар

Дарга, тэргүүлэх аудитор

Б.Мөнхбат

Аудитын менежер

Д.Цэцэгмаа

Тайланг бэлтгэсэн:

Ахлах аудитор

А.Цээням

Аудитор

Г.Ганчимэг

2019 оны 06 дугаар сарын 28

Уг тайланг УАГ-ын Цахим хуудаснаас үзнэ үү: www.audit.mn

Аудитын тайлантай холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70442424 дугаарын утас, 70442584 дугаарын факсаар харилцана уу.

ХАЯГ:

Баянхонгор аймаг дахь
Төрийн аудитын газар
Аймгийн ЗДТГ-ын байр,
Баянхонгор сум,
Баянхонгор аймаг-
64000
Монгол Улс

**Аудит хийсэн
үндэслэл, бүрэн
эрх****Аудитын зорилт****Аудитын
хамарсан хүрээ****Аудитын арга
зүй****Аудитад
ашигласан
шалгуур
үзүүлэлт****Аудитын зорилт, арга зүй, стандартын талаарх мэдэгдэл**

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын 2019 онд нийлүүлэх аудитын болон ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийлээ.

Аймгийн цагдаагийн газрын тээврийн хэрэгсэл түр саатуулах хашаа /байр/-ны орлогыг хууль, тогтоомжийн дагуу бүрэн төвлөрүүлсэн эсэх, түүний зарцуулалтыг шалгаж, аудитын дүн, дүгнэлт гаргаж, зөвлөмж боловсруулж, аймгийн ИТХ, холбогдох байгууллагад танилцуулахад чиглэгдэв.

Дээрх ерөнхий зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэв. Үүнд:

- Аймгийн Цагдаагийн газрын тээврийн хэрэгсэл түр саатуулах хашаа /байр/-ны үйл ажиллагаа нь хууль тогтоомжид нийцсэн;

- Аймгийн Цагдаагийн газрын тээврийн хэрэгсэл түр саатуулах хашаа /байр/-ны орлогыг хууль тогтоомжийн дагуу бүрэн төвлөрүүлсэн эсэх;

Тус аудитад аймгийн Цагдаагийн газрын Замын цагдаагийн тасаг болон “Мөнхболд Жигүүр” ХХК-ний 2016 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэлх хугацааны мэдээ, тайлан, бүртгэл судалгааг хамруулж, холбогдох шийдвэр, баримт материалыг түүвэрлэн шалгав.

Аудитыг гүйцэтгэхэд Төрийн хяналт шалгалтын стандарт, АДБОУС 100-400, 4000, стандартууд болон, холбогдох албан тушаалтнуудтай уулзалт, ярилцлага зохион байгуулах зэрэг аудитын арга зүйг ашиглаж, аудитын хөтөлбөр, горимын дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

Дараах хууль эрхийн актыг аудитын шалгуур үзүүлэлтийн эх сурвалж болгон ашиглав. Үүнд:

Хуулиуд:

- Төрийн аудитын тухай хууль;
- Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль;
- Төсвийн тухай хууль;
- Иргэний хууль;
- Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль;
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль;
- Хууль зүйн сайдын 2015 оны 8 дугаар сарын 28 ны өдрийн А/190 дугаар тушаалын 2 дугаар хавсралт;
- Баянхонгор аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2018 оны 02 дугаар сарын 6 ний өдрийн хуралдааны 12 дугаар тогтоол;

**Ерөнхий зүйл:**

Замын хөдөлгөөний аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөх үйлдлийг таслан зогсоох, замын хөдөлгөөнд оролцогчдын хэвийн, аюулгүй зорчих нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор тээврийн хэрэгслийг зөөж шилжүүлэх, түр саатуулахтай холбогдон үүсэх харилцааг зохицуулахаар Хууль зүйн сайдын 2015 оны А/190 дүгээр тушаалын хоёрдугаар хавсралтаар “Тээврийн хэрэгслийг зөөж шилжүүлэх, түр саатуулах журам”-ыг баталсан байна.

Аудитад хамрагдсан онуудад Аймгийн Цагдаагийн газрын “Тээврийн хэрэгсэл түр саатуулах хашаа”-г 2016 оны 1 дүгээр сарын 01 ний өдрөөс эхлэн 2016 оны 3 дугаар сарын 31 ний өдрийн хүртэлх хугацаанд аймгийн Цагдаагийн газар, 2016 оны 4 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн “Мөнхболд Жигүүр” ХХК гэрээний үндсэн дээр хариуцан ажиллуулсан байна.

2016-2018 онд хууль, журмын дагуу 4692 авто тээврийн хэрэгсэл түр саатуулагджээ.

Хүснэгт:1 Саатуулагдсан тээврийн хэрэгслийг төрлөөр авч үзвэл

Он	Мотоцикл /тоо/	Суудлын болон 3.5 тн хүртэлх жинтэй ачааны автомашины /тоо/	3.5 тн дээш жинтэй ачааны автомашин /тоо/	Нийт дүн
2016	452	1138		1590
2017	348	1228	1	1577
2018	518	1005	2	1525
Төрлийн дүн	1318	3371	3	4692



АУДИТЫН ДҮН

Дүгнэлт: Цагдаагийн газрын түр саатуулах хашаа /байр/-ны үйл ажиллагааны орлогыг хууль тогтоомжийн дагуу бүрэн төвлөрүүлээгүй байна.

Бүлэг 1: Тээврийн хэрэгсэл түр саатуулах хашаа/байр/-ны зарим үйл ажиллагаа нь журамд нийцэхгүй байна.

Тээврийн хэрэгслийг түр саатуулах хашаа /байр/-ыг ажиллуулах шийдвэрийг аймгийн ИТХ-аас гаргасан боловч, гэрээгээр гүйцэтгүүлэх аж ахуй нэгжийг сонгохдоо сонгон шалгаруулалт явуулаагүй, гэрээний хэрэгжилтийг дүгнэж ажиллаагүй байна.

1. Монгол улсын Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.4¹ дахь заалт, Хууль зүйн сайдын 2015 оны А/190 дүгээр тушаалыг 02 дугаар хавсралтаар батлагдсан “Тээврийн хэрэгслийг зөөж шилжүүлэх, түр саатуулах журам”-ын 3 дахь хэсгийн 3.2 дахь заалтыг үндэслэн Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2016 оны 12 дугаар тогтоолоор “Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөх үйлдлийг таслан зогсоох, хөдөлгөөнд оролцогчдын хэвийн аюулгүй зорчих нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор аймгийн төвд 900м² талбай бүхий “Тээврийн хэрэгслийг түр саатуулах хашаа /байр/-ыг ажиллуулах” шийдвэрлэжээ

2. Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдааны 2016 оны 12 дугаар тогтоолын 3-т “Тээврийн хэрэгслийг түр саатуулах хашаа/байр/ ажиллуулахад тавигдах шаардлагыг хангасан аж ахуйн нэгж байгууллагыг сонгон шалгаруулж, гэрээ байгуулан ажиллах”-ыг Аймгийн Засаг даргад хариуцуулсан байхад сонгон шалгаруулалт явуулаагүй, Хууль зүйн сайдын 2015 оны А/190 дүгээр тушаалаар батлагдсан “Тээврийн хэрэгслийг зөөж шилжүүлэх, түр саатуулах журам”-ын 3.3² дахь заалтыг зөрчин харуул хамгаалалтын тусгай зөвшөөрөл бүхий “Мөнхболд жигүүр” ХХК-тай аймгийн Засаг даргын орлогч 2016 оны 03 дугаар сарын 31 ний өдөр “Авто тээврийн хэрэгслийг түр саатуулах хашааны хамгаалалт”-ын гэрээг байгуулж, одоо хүртэл гэрээг дахин сунгаагүй байна.

Гүйцэтгэгч “Мөнхболд Жигүүр” ХХК нь “Тээврийн хэрэгслийг зөөж шилжүүлэх, түр саатуулах журам”-ын 3.4. “Тээврийн хэрэгслийн түр саатуулах хашаа /байр/ ажиллуулах байгууллага нь өөрийн эзэмшлийн зориулалтын чирэгч, ачигч автомашинтай байна. Зөөж шилжүүлэх үеийн аюулгүй байдлыг хангуулах зорилгоор жолоочоос гадна техникийн ажилтан ажиллуулна” гэсэн тусгай шаардлагыг хангаагүй байна.

¹ харьяа нутаг дэвсгэрийн хэмжээнд тээврийн хэрэгслийг зөөж шилжүүлэх, тээврийн хэрэгслийг түр саатуулах хашаа /байр/ ажиллуулах шийдвэр гаргах, төлбөрийн хувь хэмжээг тогтоох.

² Тээврийн хэрэгслийг зөөж шилжүүлэх, түр саатуулах журмын 3.3²-т Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нь энэхүү журмын 3.2-т заасан шийдвэрийн дагуу тээврийн хэрэгслийг зөөж шилжүүлэх, түр саатуулах хашаа /байр/ ажиллуулахад тавигдах шаардлагыг хангасан аж ахуйн нэгж, байгууллагыг сонгон шалгаруулж, ажил, үйлчилгээ гүйцэтгүүлэх гэрээ байгуулна

3. Монгол улсын Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, дүрэм Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журмын 411 дүгээр кодоор батлагдсан “Тээврийн хэрэгслийг хадгалах”-д нийцүүлэн гаргасан эрх зүйн актуудыг хэрэгжүүлэх зорилгоор Аймгийн Засаг дарга, Цагдаагийн газар, “Мөнхболд Жигүүр” ХХК-тай 2016 оны 03 дугаар сарын 31 ний өдрөөс эхлэн “Авто тээврийн хэрэгслийг түр саатуулах хашааны хамгаалалтын гэрээ”-г нэг жилийн хугацаатай байгуулж ажилласан боловч харилцагч талууд гэрээний хэрэгжилтийг гаргаж биелэлтийг дүгнэж ажиллаагүй байна.

Аудитын илрүүлэлт:

Хамгаалалтын гэрээний 5 дахь хэсгийн 5.1-д “гэрээг цаашид сунгах эсэхийг хугацаа дуусахаас өмнө биелэлтийг дүгнэж талууд харилцан тохиролцоно, хэрэв хамгаалуулагч тал гэрээг цуцлах тохиолдолд 14 хоногийн өмнө энэ тухайгаа хамгаалагч талд мэдэгдэнэ, гэрээний хугацаа дуусахад 2 талын байгууллага гэрээг цуцлах талаар санал тавихгүй бол энэхүү гэрээг мөн хугацаагаар сунгасанд тооцно” гэж гэрээнд тусгасан ба гэрээг дахин байгуулаагүй байна.

Тээврийн хэрэгслийг түр саатуулах хашаа /байр/ нь Хууль зүйн сайдын 2015 оны А/190 дүгээр тушаалаар батлагдсан “Тээврийн хэрэгслийг зөөж шилжүүлэх, түр саатуулах журам”-ын 4 дүгээр зүйлд заасан шаардлагыг бүрэн хангахгүй байна.

4. “Мөнхболд Жигүүр” ХХК-ний Шонхор гэрээт харуул хамгаалалтын алба нь хамтран ажиллах гэрээний 5.4 дэх хэсэгт заасны дагуу Аймгийн цагдаагийн газрын эзэмшлийн 650 м2 талбай бүхий “Тээврийн хэрэгсэл түр саатуулах” хашааг ашиглаж үйл ажиллагаа явуулж, харуулын алба хаагчид ажлын байр, ажлын хувцас, тусгай хэрэгсэл, холбоо мэдээллийн тоног төхөөрөмжөөр хангагдсан боловч “Тээврийн хэрэгсэл зөөж шилжүүлэх, түр саатуулах” журамд заасан Тээврийн хэрэгслийг түр саатуулах хашаа /байр/-нд тавигдах шаардлагыг бүрэн хангахгүй байна.



Аудитын илрүүлэлт:

“Тээврийн хэрэгслийг зөөж шилжүүлэх, түр саатуулах журам”-ын 4.1-д заасан Тээврийн хэрэгслийг түр саатуулах хашаа /байр/ нь даатгалтай харуул хамгаалалтын ажилтантай, ил болон битүү зогсоолын хүрэлцэхүйц талбайтай, хашаа нь тортой, галын аюулгүй байдлын болон тээврийн хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг хянах боломж бүхий камерын хяналтын системтэй, харанхуй үед үзэгдэх боломжийг хангасан гэрэлтүүлэгтэй байна гэсэн шаардлагыг хангахгүй байна.

5. Тус албанаас “тээврийн хэрэгсэл түр саатуулах хашаа”-ны өдөр тутмын аюулгүй ажиллагаанд харуул хамгаалалт эрхэлсэн дэд захирал хяналт тавьж, хамгаалалтын 3 албан хаагч харуулын үүрэг гүйцэтгэж иржээ.



“Тээврийн хэрэгслийг зөөж шилжүүлэх, түр саатуулах журам”-ын дагуу саатуулагдсан тээврийн хэрэгслийг хүлээж авахдаа Цагдаагийн алба хаагчийн хүргэж ирсэн тээврийн хэрэгслийг хашаанд нэвтрүүлж, эзэмшигч, ажилтныг байлцуулан тээврийн хэрэгслийн гадна тал, ачаа, тээшийг /үзлэгийн тэмдэглэл/-тэй тулгаж түр саатуулагдсан тээврийн хэрэгслийн бүртгэлд бүртгэн тэмдэглэл хөтөлж, мөн түр саатуулагдсан тээврийн хэрэгслийг жолооч /эзэмшигч, өмчлөгч/-д хүлээлгэн өгч, хашаанаас гаргахдаа харьяа нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллагын зохицуулагчийн шийдвэрээр тээврийн хэрэгслийг жолооч /эзэмшигч, өмчлөгч/-д хүлээлгэн өгч бүртгэл хөтөлж ажилласан байна.

Тээврийн хэрэгсэл түр саатуулах хашааг гэрээгээр ажиллуулж байгаа аж ахуй нэгжийн үйл ажиллагаа, гарсан шийдвэр, гэрээний хэрэгжилтэд аймгийн ИТХ, Засаг дарга хяналт тавьж ажиллаагүй байна.

6. Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2016 оны 12 дугаар тогтоолын 2 дахь заалтад “Тээврийн хэрэгслийг түр саатуулах хашаа/байр/-нд түр саатуулагдсан авто тээврийн хэрэгслийн нэг хоногийн төлбөрийн хэмжээг тогтоох тухай” шийдвэрийг “Мөнхболд жигүүр” ХХК мөрдөн ажилласан байна. Харин дээрх тогтоолын 3 дахь заалтад үйл ажиллагаанд нь ИТХ-ын нарийн бичгийн дарга хяналт тавихаар заасан байхад тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллаагүй байна.

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2018 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн 50 дугаар тогтоолоор аймгийн Цагдаагийн газрын Тээврийн хэрэгсэл түр саатуулах хашаанд байгаа мотоциклын хадгалалт хамгаалалтыг шалгаж, танилцуулах ажлын хэсэг байгуулсан байна.

Дээрх ажлын хэсгийн дүгнэлтийг хэлэлцэн аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2018 оны 07 дугаар сарын 07 ний өдрийн 84 дүгээр тогтоолоор тээврийн хэрэгсэл түр саатуулах хашаанд саатуулагдсан 28 автомашин, 95 мотоцикльд журмын хашааны төлбөрийн хөнгөлөлт үзүүлжээ.

7. “Авто тээврийн хэрэгслийг түр саатуулах хашааны хамгаалалтын гэрээ”-ний Баянхонгор аймгийн Цагдаагийн газрын хүлээх үүргийн 3.3³-т заасны дагуу Аймгийн Цагдаагийн газрын замын цагдаагийн тасгаас түр саатуулагдсан тээврийн хэрэгсэлд үзлэг хийж тэмдэглэл хөтөлж харуулын ажилтанд хүлээлгэн өгч, шийдвэрлэсний дараа холбогдогч тээврийн хэрэгслийг олгохдоо бүрэн бүтэн байдлыг эздээр нь шалгуулж, саатуулах үеийн бүртгэлтэй тулгаж өдөр тутмын үүрэг гүйцэтгэлээр хяналт тавьж ажилласан байна.

Тээврийн хэрэгслийн хадгалалт хамгаалалттай холбоотой гомдол санал Аймгийн Цагдаагийн газар болон “Мөнхболд Жигүүр” ХХК-д ирээгүй байна.

8. Авто тээврийн хэрэгслийг түр саатуулах хашаанд журамлагдсан авто тээврийн хэрэгслийг холбогдох эзэмшигч иргэд нь түр саатуулах хашааны төлбөр төлөхөөс зайлсхийдэг, удаан хугацаагаар авто тээврийн хэрэгслээ авахгүй байгаа зэрэг шалтгааны улмаас эзэмшигч нь аваагүй авто тээврийн хэрэгслээс хуулийн

³ Саатуулагдсан тээврийн хэрэгсэл бүрийг зохих журмын дагуу түр саатуулах хашааны хамгаалалтанд хүлээлгэн өгөх, бүрэн бүтэн буцааж олгож байгаа байдалд хяналт тавьж ажиллана”



дагуу худалдан борлуулж 7490,0 мянган төгрөгийг орлого болгох шийдвэр гарч 3515,0 мянган төгрөгийг аймгийн орон нутгийн орлогын хүү торгуулийн дансанд, 3975,0 мянган төгрөгийг “Мөнхболд жигүүр” ХХК-д төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 1. Улсын орлого болгосон тээврийн хэрэгсэл

Он	Үнэлгээ/төг/	Мотоцикль тоо	Автомашин тоо	Мөнгөн дүн
2016	5000	1		5000
	10000	51		510000
	20000	3		60000
	30000	5		150000
2017	50000	15		750000
	30000	68		2040000
2018	75000	1		75000
	100000	9		900000
	150000	10		1500000
	300000		5	1500000
Дүн		183	5	7490000

Аудитын илрүүлэлт:

- Аймгийн Засаг даргад Аймгийн Цагдаагийн газар 2016.02.12-ний 31-1/366 дугаар албан бичгээр 2014 оны 12 дугаар сарын хойш захиргааны зөрчил гаргасны улмаас түр саатуулагдсан 60 ш мотоциклыг үнэ тогтоож худалдан борлуулж өгөх хүсэлтийг хүргүүлсний дагуу аймгийн Засаг даргын дэргэдэх Захиргааны зөвлөлийн 2016.03.25-ны өдрийн хуралдаанаар улсын орлого болгох үнэлгээг тогтоон худалдан борлуулж орон нутгийн орлогод 725,0 мянган төгрөгийг төвлөрүүлжээ.
- 2017 онд аймгийн Засаг даргын 2016.12.05-ний өдрийн А/149 тоот захирамжийн дагуу захиргааны зөрчлийн улмаас түр саатуулагдаж, хөөн хэлэлцэх хугацаа дууссан 70 ш мотоциклд үнэлгээ тогтоож, журмын дагуу худалдан борлуулж орон нутгийн орлогод 2790, мянган төгрөгийг төвлөрүүлж, 10 мотоциклыг “Овоотын 0166 дугаар цэргийн ангид хүлээлгэж өгсөн байна.
- 2018 онд аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2018 оны 07 дугаар сарын 07 ний өдрийн хуралдааны 84 дүгээр тогтоолын дагуу Захиргааны зөрчлийн улмаас саатуулагдсан, зөрчил хянан хэлэлцэх хугацаа дууссан 5 ш машин, 20 ш мотоциклыг, гэрээний 2.6-д заасан 30%-ын төлбөрийг бүрэн чөлөөлж, журмын хашааны төлбөрт 3975,0 мянган төгрөгийг “Мөнхболд жигүүр” ХХК-ийн дансанд төвлөрүүлсэн байна.

Мөн Аймгийн Цагдаагийн газрын “Тээврийн хэрэгсэл түр саатуулах хашаа”-нд 2018 оны 07 дугаар сарын 07 ний өдрийн Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 84 тогтоолоор төлбөрийн хөнгөлөлт үзүүлэх шийдвэр гарсан дээрх тээврийн хэрэгслээс 19 автомашин, 57 мотоциль, 2017 оны 07 дугаар сарын 01 өдрөөс хойш саатуулагдсан зөрчлийн хуулиар шийдвэрлэгдэх 90 мотоциклыг эзэмшигч нь аваагүйгээс түр саатуулах хашаа/байр/-нд байна.

Бүлэг2: Тээврийн хэрэгслийг түр саатуулах хашаа/байр/-ны орлогыг бүрэн төвлөрүүлээгүй байна.



Тээврийн хэрэгслийг түр саатуулах хашаа /байр/-ны үйл ажиллагааны төлбөрийг аймгийн ИТХ-аас гаргасан тогтоолын дагуу хурааж байгаа боловч гэрээний дагуу орлогыг бүрэн төвлөрүүлж ажиллаагүй байна.

9. Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2016 оны 02 дугаар сарын 26 ний өдрийн 12 дугаар тогтоолоор тээврийн хэрэгслийг зөөж шилжүүлэх, түр саатуулах үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуйн нэгж, байгууллагын түр саатуулах хашаа/байр/-ны талбай хэмжээг 900 м², нэг хоногийн төлбөрийг мотоцикль 2000 төгрөг, суудлын автомашин 3,5 тонн хүртэлх жинтэй бүх төрлийн ачааны машин 4000 төгрөг, 3,5 тонноос их даацтай бүх төрлийн том оврын автомашин 6000 төгрөг байхаар тогтоосон байна.

10. 2016-2018 онд нийт 72174,1 мянган төгрөгийн төлбөрийг Тээврийн хэрэгслийг түр саатуулах хашаанд журамлагдсан тээврийн хэрэгслээс аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2016 оны 12 дугаар тогтоолын дагуу тооцон хурааж авсан байна. Дээрх орлогоос аймгийн Цагдаагийн газар 4935,0 мянган төгрөгийг төлбөрийг хураан авч, Төсвийн тухай хуулийн 41.2.1⁴ дэх заалтын дагуу Цагдаагийн Ерөнхий газарт төвлөрүүлсэн.

Мөн “Мөнхболд жигүүр” ХХК нь 2016 оны 4 дүгээр 1 өдрөөс 2018 оны 12 дугаар сарын 31 ний хүртэлх хугацаанд 67239,1 сая төгрөгийн төлбөрийг хураан авч орон нутгийн төсөвт 15040,0 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.



Аудитын илрүүлэлт:

➤ “Мөнхболд Жигүүр” ХХК ний түр саатуулагдсан тээврийн хэрэгслийн бүртгэл, цагдаагийн газрын замын цагдаагийн тасгийн бүртгэл, зөвшөөрлийн бичгийг тулган шалгахад 2112,0 мянган төгрөгийн төлбөрийг аваагүй байгаа нь гэмт хэргийн улмаас эд мөрийн баримтаар хураагдсан, хэргийн хөөн хэлэлцэх хугацаа дуусаж улсын орлого болгосон, тээврийн хэрэгслээс түр саатуулах хашааны хураамж аваагүйтэй холбоотой байна. Цаашид төлбөрөөс чөлөөлөгдөж буй тээврийн хэрэгслийн бүртгэлийг тус нь хөтөлж, аймгийн Цагдаагийн газрын Замын цагдаагийн тасгийн албан тоотын дагуу шийдвэрлэж байх зөвлөмжийг хүргүүллээ.

11. “Авто тээврийн хэрэгслийг түр саатуулах хашааны хамгаалалт”-ын гэрээний нэмэлт заалтад авто тээврийн хэрэгслийг түр саатуулах хашааны үйлчилгээний төлбөрийг орсон орлогын 70 хувиар тооцож компанийн үйл

⁴ “хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх”



ажиллагааны санхүүжилтэд сар бүрийн 20 -ны дотор “Мөнхболд Жигүүр” ХХК-ийн “Хас” банкны 5001161633 тоот дансанд шилжүүлнэ гэж заасан боловч орлогыг аль дансанд төвлөрүүлэх нь тодорхой тусгаагүйгээс дээрх аж ахуйн нэгжийн дансанд төвлөрүүлж, гэрээний 2.6-т заасны дагуу хураамжийн 30%-ийг аймаг, орон нутгийн төсөвт оруулахаар заажээ. “Мөнхболд жигүүр” ХХК-нь дансанд төвлөрсөн орлогоос 15040,0 мянган төгрөгийг орон нутгийн орлогод оруулж, орлогыг дутуу төвлөрүүлсэн зөрчил илэрлээ.

Аудитын илрүүлэлт:

➤ Тус аж ахуй нэгжийн орлогыг 2016-2018 оны анхан шатны баримтаас тулган шалгахад гэрээний дагуу орон нутгийн төсөвт төвлөрүүлэх төлбөр, хураамжийн орлогоос 3100,0 мянган төгрөгийг дутуу төвлөрүүлснийг Мөнхболд жигүүр ХХК-иар төлүүлж орон нутгийн орлогод төвлөрүүлэхээр төлбөрийн акт тогтоов.

12. Аймгийн Засаг даргын орлогч, “Мөнхболд жигүүр” ХХК –ний хооронд байгуулсан гэрээний нэмэлт заалтад авто тээврийн хэрэгслийн түр саатуулах хашааны орлогыг сарын бүрийн 20 ний дотор тооцож ажиллана гэж заасан байхад гүйцэтгэлийг тайлагнаагүй, тооцоо нийлж ажиллаагүй байна.

Орон нутгийн өмчийн эд хөрөнгийг ашигласны төлбөрийг гэрээнд 2017 оны 1-р сараас эхлэн харилцан тохирч төлөхөөр заасан байхад төлбөр төлөөгүй байна.

13. Авто тээврийн хэрэгслийг түр саатуулах хашааны хамгаалалтын гэрээний 5.4 дэх хэсэгт “Цагдаагийн газрын тээврийн хэрэгсэл түр саатуулах хашааг ашиглаж болно. 2017 оны 01 дүгээр сарын 01-ээс хойш Цагдаагийн газрын тээврийн хэрэгсэл түр саатуулах хашааг ашиглах бол харилцан тохиролцож төлбөр төлнө” гэж заасан боловч ямар нэгэн эрх зүйн акт гаргаж түрээсийн төлбөрийг тооцож аваагүй байна.

Аудитын илрүүлэлт:

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2009 оны 19 дүгээр тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчийн барилга, байгууламж болон үндсэн хөрөнгийг түрээсээр эзэмшүүлэх” журмын 2 дугаар хавсралт⁵-ын дагуу 650м² хашааны түрээсийн төлбөрийг тооцож үзэхэд 3510,0 мянган төгрөгийг төсөвт оруулах боломжийг алдсан байна.

Иймд Орон нутгийн өмчийг хууль тогтоомж дагуу орон нутгийн өмчийг түрээслүүлэх гэрээ байгуулж, түрээсийн төлбөрийг тооцож ажиллан, өмнөх онуудын Цагдаагийн газрын тээврийн хэрэгсэл түр саатуулах хашааг ашигласны төлбөрийг харилцан тохирч авч, орон нутгийн орлогод оруулах зөвлөмжийг аймгийн Засаг даргад хүргүүлэв.

14. “Мөнхболд Жигүүр” ХХК-нь 2016 оны 04 дүгээр сарын 1 ний өдрөөс эхлэн Аймгийн Цагдаагийн газрын тээврийн хэрэгсэл түр саатуулах хашааг ашиглаж үйл ажиллагаа явуулж байгаа боловч тухайн байгууллагын санхүүгийн тайлан, дансны хуулгаас харахад 2017 онд 84,0 төгрөгийн цахилгааны зардал төлж, хашааны урсгал засварын ажилд дансаар мөнгө гараагүй, тухайн байгууллага нь цалин, хоол, шатахууны зардал нэрээр дансанд орсон мөнгийг кассаар бэлнээр гарган зарцуулж ирсэн байна.

⁵ Түрээсийн төлбөрийг 1м² ашигтай талбайн доод үнэ/ төгрөгөөр/ бусад-2700

**АУДИТЫН ДҮГНЭЛТ**

Нийцлийн аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг өгч байна. Үүнд:

1. Тээврийн хэрэгслийг түр саатуулах хашаа /байр/-ыг ажиллуулах шийдвэрийг аймгийн ИТХ-аас гаргасан боловч тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллаагүй байна.

2. Хууль зүйн сайдын 2015 оны А/190 дүгээр тушаалын хоёрдугаар хавсралтын 3.3 дэх заалтыг зөрчиж тээврийн хэрэгслийг түр саатуулах хашаа /байр/-г ажиллуулах аж ахуй нэгжийг шалгаруулахдаа сонгон шалгаруулалт явуулаагүй шууд гэрээ байгуулж, гэрээний хэрэгжилтийг дүгнээгүй байна.

3. Тээврийн хэрэгслийг түр саатуулах хашаа /байр/ нь Хууль зүйн сайдын 2015 оны А/190 дүгээр тушаалаар батлагдсан “Тээврийн хэрэгслийг зөөж шилжүүлэх, түр саатуулах журам”-ын 4 дүгээр зүйлд заасан шаардлагыг бүрэн хангаагүй, галын аюулгүй байдлын болон тээврийн хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг хянах боломж бүхий камерын хяналтын системгүй байна.

4. Тээврийн хэрэгслийг түр саатуулах хашаа /байр/-ны үйл ажиллагааны төлбөрийг аймгийн ИТХ-аас гаргасан тогтоолын дагуу хурааж байгаа боловч гэрээний дагуу орлогыг орон нутгийн орлогод бүрэн төвлөрүүлээгүй байна.

5. Орон нутгийн өмчийн эд хөрөнгийг ашигласны төлбөрийг гэрээнд 2017 оны 1-р сараас эхлэн харилцан тохирч төлөхөөр заасан байхад төлбөр төлөөгүй байна.

АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Нэг. Аймгийн ИТХ-ын дарга Ц.Отгонбаяр танаа

1. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.4 дэх бүрэн эрхийн хүрээнд аймгийн ИТХ “тээврийн хэрэгслийг түр саатуулах хашаа /байр/-ыг ажиллуулах талаар гаргасан тогтоол, шийдвэрийнхээ биелэлтэд хяналт тавьж ажиллах.

Хоёр. Аймгийн Засаг дарга Г.Батжаргал танаа

1. Тээврийн хэрэгслийг түр саатуулах хашаа/байр/ ажиллуулахад тавигдах шаардлагыг хангасан аж ахуй нэгж, байгууллагыг сонгон шалгаруулж, ажил, үйчилгээ гүйцэтгүүлэх гэрээ байгуулж ажиллах.

Гурав. Аймгийн Цагдаагийн газрын дарга Ц.Анхбаяр танаа

1. Авто тээврийн хэрэгслийг түр саатуулах хашааны хамгаалалтын гэрээний 5.4 дэх хэсэгт заалтыг хэрэгжүүлж, түрээсийн төлбөрийг тооцох мөн орон нутгийн өмчийн тухай хууль тогтоомжийн дагуу орон нутгийн өмчийг бусад ашиглуулж буй тохиолдолд түрээсийн гэрээг байгуулж ажиллах.

Байгууллагын санал: санал ирээгүй болно.

